

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛЖ БУЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ САНАА, ШҮҮМЖ

ОРШИЛ

Төлөөллийн ардчилалд парламент нь хууль тогтоох үндсэн үүргээ гүйцэтгэхдээ ил тод байдлыг хангаж, иргэдийг оролцуулахын зэрэгцээ судалгаа шинжилгээнд үндэслэн хэрэгжих боломжтой амьдралд нийцсэн хууль гаргахад анхаарах учиртай. Энэ зарчмуудыг зохих хуулиудад тодорхой тусгасан хэдий ч сүүлийн жилүүдэд хэрэгжүүлэхгүй байх үзэгдэл газар авч шүүмжлэл дагуулах болсон билээ.

Монгол Улсын Их Хурал 2024-2028 оны стратеги төлөвлөгөөндөө “хүн төвт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлэх” зорилго тусган, энэ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хууль (ХТтХ)-ийг шинэчлэх¹ ажлыг эхлүүлээд байна. Ингэснээр хуулийн төсөл боловсруулах үйл явцад нээлттэй байдал, олон талын оролцоог хангахад учирч ирсэн олон асуудлыг шийдвэрлэх боломж нээгдэж буй юм. Иймд Нээлттэй нийгэм форумын зүгээс УИХ-д өргөн баригдаад буй Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд дүн шинжилгээ хийн дараах шүүмжийг толилуулж байна. Хуулийн зорилго ил тод байдал, олон нийтийн оролцоог хангах, үр нөлөөг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн зарим заалт туссан нь сайшаалтай ч тодорхой процессоор дамжин хэрэгждэг энэхүү эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд хангалтгүй байна.

Шүүмжийг боловсруулахад ННФ-аас 2024-2025 онд хийж гүйцэтгэсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг тодорхой зохицуулалтын хүрээнд лавшруулан авч үзсэн цуврал судалгаа болон энэхүү сэдвийн хүрээнд зохион байгуулсан цуврал хэлэлцүүлгийн явцад хөндөгдсөн асуудлууд, судлаачдын саналыг иш болгов.

¹ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, <https://law-forum.parliament.mn/project/712/>

Нэг. Олон нийтийн хэлэлцүүлэг

УИХ-д өргөн мэдүүлэгдсэн хуулийн төслийн Үзэл баримтлалд нэмэлт, өөрчлөлт нь хууль тогтоох үйл ажиллагааны бүх үе шатанд хүн төвт үзэл санааг баримтлах, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх хууль зүйн баталгаа бүрдүүлэх шаардлагад үндэслэсэн болохыг дурджээ. Тэгвэл хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үр дагавар бүхий хууль тогтоомж батлагдан гарахаас сэргийлэх гол арга, шүүлтүүр нь хууль бүтээх үйл ажиллагаанд анхнаас нь олон нийтийн оролцоог хангах явдал юм. 2020-2024 онд боловсруулсан 254 хуулийн төслийн дөнгөж 39 хувьд нь олон нийтийг оролцуулсан байгаа нь² хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл явцын нээлттэй байдал, иргэдийн оролцоо зохих түвшинд хангагдаж чадахгүй байгааг илтгэж байна.

Үүний нэг гол шалтгаан нь ХТХ-д заасан олон нийтийн хэлэлцүүлэг явуулахгүй байх нөхцөлийг улам бүр өргөжүүлсээр байгаа явдал юм. Тус хууль анх батлагдахад судалгаа, шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлэг шаардахгүй нөхцөлийг тодорхойлсон 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг байгаагүй билээ. Харин 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт оруулснаар, 12 дугаар зүйлийн 12.2-т нийт 16 нөхцөлийг заасан байх ба үүнээс дөнгөж нэг сарын дараа 2017 оны 5 сарын 12-ны нэмэлт өөрчлөлтөөр дахин найман нөхцөлийг нэмж тусган олон нийтийг оролцоог хязгаарлажээ. Улмаар 2023-2024 оны өөрчлөлтөөр таван нөхцөлийг хассанаар эдүгээ судалгаа, шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлэг шаардахгүй 19 үндэслэл тус хуульд байна. Үүнд яаралтай горим, төрийн захиргааны байгууллагын бүтэц, тогтолцоог өөрчлөх, УИХ-ын үйл ажиллагаатай холбоотой хуулиуд, төсвийн гүйцэтгэл, онцгой албан татвар зэрэг олон нийтээр зайлшгүй хэлэлцүүлэх учиртай асуудлууд багтсан байна. Тухайлбал, төсвийн гүйцэтгэл болон онцгой албан татвар зэрэг нь ХТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.4-т заасан 60-аас доошгүй хоногийн хугацаанд санал авах шаардлагатай бизнесийн орчинд нөлөөлөх асуудлууд юм. Тэрчлэн УИХ нь төлөөллийн ардчиллын гол институт төдийгүй хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны нэг чухал хэсэг болохын хувьд түүний үйл ажиллагаанд холбогдох Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай (МУИХЧХДТХ) зэрэг хуулийг зайлшгүй олон нийтээр хэлэлцүүлэх учиртай.

Зөвлөмж:

- ХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан судалгаа, шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлэг шаардахгүй нөхцөлүүдийг хумьж, цаашид өргөжүүлэхийг хориглох,

² “2020-2024 онд боловсруулсан-254 хуулийн төслөөс дөнгөж 99-ийг нь л ямар нэг түвшинд олон нийтээр хэлэлцүүлжээ”, “Хууль тогтоомжийн төслийн ил тод байдал, олон нийтийн хэлэлцүүлгийн шаардлагын хэрэгжилт” судалгааны тайлан, 36 дугаар хуудас, <https://forum.mn/product/459176>

- Ил тод байдал, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад тавих үндсэн шаардлагыг илүү нарийвчлан хуульчлах замаар иргэдийн оролцооны эрхийг бүрэн хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх. Тухайлбал, эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх талуудыг судалгаагаар оновчтой тодорхойлж, хууль тогтоомжийн төслийг тэдний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн хэлбэрээр тухайлан танилцуулж, санал авах, эдгээр шаардлагыг хэрэгжүүлээгүй бол хууль тогтоомжийн төслийг буцаах зэрэг процессын нарийн зохицуулалтыг хуульчлах.

Хоёр. Яаралтай горимоор хууль баталж буй асуудлаар

Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд 120 гаруй хуулийг ХТХ-ийн 12.2-т заасан үндэслэлээр олон нийтийн хэлэлцүүлэггүй баталсны 45 нь яаралтай горимоор батлагдсан байна. Эдгээрийн дотор Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай,³ Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль зэрэг Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үр дагавар бүхий хуулиуд ч багтжээ. Тэрчлэн 2024 онд батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хууль, түүнийг дагалдуулан Ашигт малтмалын тухай хуульд оруулсан өөрчлөлт буюу стратегийн орд эзэмшигч хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүй эзэмших, энэ заалтыг хэрэгжүүлээгүй хувийн өмчит хуулийн этгээдэд бүрэн эрхт төлөөлөгч томилох зохицуулалт нь хөрөнгө оруулагчдад болгоомжлол төрүүлэн, нэлээд маргаан шүүмжлэл дагуулсан билээ. Энэ мэт хөрөнгө оруулалтын орчинд нөлөө бүхий, хэрэгжүүлэх явцад маргаан дагуулах, хүний өмч хөрөнгө, Үндсэн хуулиар баталгаажсан эрхтэй холбогдох хуулийн төслийг ХТХ-дийн 38.4-т заасны дагуу 60-аас доошгүй хугацаанд олон нийтээр хэлэлцүүлэх нь зүйд нийцнэ.

Хуулийг дээрх жишээнд дурдсанаар яаралтай горимоор батлахад МУИХЧХДТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг буюу “үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах”⁴ гэснийг үндэслэл болгож байна. Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал хэмээх ойлголт нь эдийн засгийн олон тулгуурт бүтэц, хөрөнгө оруулалтын бодлого, төсөв санхүүгийн салбарын аюулгүй байдал, эрдэс баялгийн салбар, гадаад худалдаа, интеграцийн бодлого⁵ зэрэг олон асуудлыг хамарсан өргөн хүрээтэй төдийгүй, түүнийг “хангах” гэсэн томъёолол нь ч мөн

³ Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлснийг УИХ мөн оны 1 дүгээр сарын 20-ны өдөр хэлэлцэн баталжээ. Хүний эрх, эрх чөлөөг хөндөх үр дагавар бүхий зохицуулалт агуулсан уг хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ хүлээн авч тус хуулийг хүчингүй болгосон юм.

⁴ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.”

⁵ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2 дахь хэсэг.

хэт ерөнхий юм. Тодруулбал, ийм өргөн хүрээнд хамаарах олон асуудлыг “хангах” гэсэн ерөнхий зорилго дурдан үндсэндээ ямар ч хууль тогтоомжийг яаралтай горимоор олон нийтийн хэлэлцүүлэг, судалгаа шинжилгээгүй батлан гаргах үүд хаалга нээлттэй байна.

Яаралтай горимоор өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд хамаарах эсэх, заавал яаралтай батлах шаардлагатай эсэхийг нягтлан шалгах зохицуулалт байхгүй нь дээрх байдалд мөн нөлөөлж байна. Тухайлбал, Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай,⁶ Аялал жуулчлалын тухай, Шүүх байгуулах тухай зэрэг яаралтай горимоор батлагдсан зарим хуулиуд үндэсний эдийн засагт ямар хамааралтай, яагаад нэн яаралтай батлах шаардлага үүссэн нь тодорхойгүй байгааг судлаачид шүүмжилжээ.⁷

Гамшиг, осол зэрэг гэнэтийн нөхцөл байдлаас үүссэн хохирол, эрсдэлийг нэн даруй арилгах зорилгоор яаралтай горимоор хууль батлах практик олон улсад байдаг ч шалгуур, үндэслэлийг тусгайлан тогтоодог байна.⁸ Үүнд:

- **Яаралтай горимоор хууль батлах үндэслэл:** Байгалийн гамшиг, осол, бусад хямрал гэх мэт урьдчилан тооцох боломжгүй гэнэтийн нөхцөл байдал үүссэн, түүний эрсдэл, үр дагаврыг бууруулах, арилгах арга хэмжээг хойшлуулшгүй авах шаардлага үүссэн, түүнийг нотолсон байх,
- **Хуулийн төсөлд тавих шаардлага:** Хуулийн үйлчлэл нь зөвхөн тухайн нөхцөл байдлын эрсдэл, үр дагаврыг бууруулах, арилгахад чиглэсэн, үндсэн хуулийн зарчим, үзэл санаа, ардчилсан нийгмийн байгуулал зэрэг зарчмын шинжтэй асуудлыг хөндөөгүй байх, цаг хугацааны хувьд байнгын шинжтэй тогтвортой үйлчлэх зохицуулалт агуулаагүй буюу нэг удаагийн шинжтэй байх,
- **Парламентын хяналт:** Парламентын хэлэлцүүлгийн явцад хуулийн төсөл нь дээрх шаардлагыг хангасан эсэхийг шалгах ба хууль баталсны дараа тогтоосон хугацаанд хэрэгжилт, үр дагаврыг нь үнэлж, олон нийтэд мэдээлэх.

⁶ Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлснийг УИХ мөн оны 1 дүгээр сарын 20-ны өдөр хэлэлцэн баталжээ. Хүний эрх, эрх чөлөөг хөндөх үр дагавар бүхий зохицуулалт агуулсан уг хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ хүлээн авч тус хуулийг хүчингүй болгосон юм.

⁷ ННФ, Бодлогын асуудал цуврал №48, “Хууль тогтоомжийг олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр хэлэлцэн батлах зохицуулалт, анхаарах асуудал”, <https://forum.mn/product/434676>

⁸ ННФ, Бодлогын асуудал цуврал №48, “Хууль тогтоомжийг олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр хэлэлцэн батлах зохицуулалт, анхаарах асуудал”, <https://forum.mn/product/434676>

Зөвлөмж:

- МУИХЧХДТХ-ийн 33.1-т заасан “үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан” гэснийг “үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд үүссэн гэнэтийн эрсдэлийг бууруулах зорилгоор” гэж өөрчлөх,
- Дээрх эрсдэлийг урьдчилан тооцох боломжгүй бөгөөд хойшлуулшгүй арга хэмжээ авах хэрэгцээ, шаардлагыг нотолсон байх,
- Яаралтай горимоор батлах хуулийн үйлчлэл нь зөвхөн тухайн эрсдэлийг бууруулахад чиглэх ба уг зорилгод хүрснээр дуусгавар болох,
- Яаралтай горимоор хууль хэлэлцэн батлах нөхцөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах боломжгүй ч хуулийн төслийг ил тод болгох шаардлага тогтоох,
- Яаралтай горимоор батлагдсан хуулийн хэрэгжилт, үр дагаврыг УИХ өөрийн бүрэн эрхийн хүрээнд тогтоосон хугацаанд эргэн үнэлэх зэрэг зохицуулалт бий болгох.

Гурав. Дагалдах хуулийн талаар

Хууль тогтоомжийг судалгаа шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлэггүй батлан гаргах өөр нэг үүд хаалга нь дагалдах хууль юм. Аливаа хууль тогтоомжийг дагалдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад тавих шаардлага, баримтлах журам тодорхойгүй байгаагаас үүдэн олон тооны хуулийг нэгэн зэрэг өөрчлөх, тэдгээр нь зарим тохиолдолд шаардлагагүй байх, тухайн хуулийн үзэл баримтлалыг өөрчлөхүйц зарчмын шинжтэй өөрчлөлт оруулах гэх мэт асуудлууд гарч ирсэн нь судалгаанаас харагдана.⁹ Тухайлбал, төсвийн тухай хууль ба түүний дагалдах хуулиудад энэ үзэгдэл илүү ажиглагдаж байна. Тодорхой жишээ дурдахад, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан 99 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бол 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Засгийн газар дахь хяналтын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай гэх анхдагч хуулиудыг баталжээ. Түүнчлэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн зэрэг нь Хууль тогтоомжийн тухай хуульд нийцсэн эсэх талаар холбогдох мэргэжилтнүүд шүүмжлэлтэй байр суурьтай байна. Өөрөөр хэлбэл, анхдагч хуулийн төслийг ХТТХ-р шаарддаг хэрэгцээ шаардлагын тандан судалгаа хийлгүй баталж болох эсэх, татварын хувь хэмжээг олон нийтээр хэлэлцүүлэхгүй нэмэгдүүлж болох эсэх, ерөөс дагалдах хуулиуд нь төсвийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхэд хамаарах эсэх нь шүүмжлэл дагуулсаар байна.

⁹ Нээлттэй нийгэм форум, Бодлогын асуудал цуврал №40 “Дагалдах хууль, түүнд тавигдах шаардлага: төсвийн тухай хуулийн дагалдах хуулиудад хийсэн дүн шинжилгээ”, 10 дахь хуудас, <https://forum.mn/product/352834>

Иймд аливаа хууль тогтоомжийг дагалдуулан бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад дагаж мөрдөх журам, дагалдах хуульд тавих шалгуур, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Зөвлөмж:

- ХТтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.3-т заасан “шаардлагатай тохиолдолд” гэснийг “тухайн хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд” гэж өөрчлөх, хуулийн төслийн Үзэл баримтлал, танилцуулгад энэ талаар тодорхой тусгах,
- Анхдагч хууль, шинэчилсэн найруулгын төсөл болон тухайн хуулийн үзэл баримтлалыг өөрчлөхүйц зарчмын шинжтэй өөрчлөлтийг дагалдах хэлбэрээр батлахыг хориглох,
- Хууль тогтоомжийн төсөлд хийх хууль зүйн дүгнэлтийн цар хүрээнд дагалдах хуулийн агуулгыг хянаж, дээрх шаардлагад нийцээгүй төслийг буцаах зохицуулалт бий болгох.

Хууль тогтоомжийн чанар, хүлээн зөвшөөрөгдөх байдал, хэрэгжих чадварыг сайжруулахад чиглэсэн цогц өөрчлөлт хийхийн тулд Хууль тогтоомжийн тухай хуулийн энэ удаагийн шинэчлэлийг нэмэлт, өөрчлөлтөөр хязгаарлалгүй, шинэчилсэн найруулгын хэмжээнд авч үзэх нь зүйтэй.

ТУСГАЙ САНАЛ

№	ХТтХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
Нэр томъёоны тодорхойлолт			
1	2 дугаар зүйл	2.1.5-д “зарчмын шинжтэй зохицуулалт” гэсэн ойлголтын хууль зүйн тодорхойлолт нэмж тусгах.	ХТтХ-ийн 21.1.6-д “зарчмын шинжтэй санал”, 33.2.1-д “зарчмын шинжтэй зохицуулалт” гэж заасан байх боловч тэдгээрийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Энэхүү ойлголт нь дагалдах хуулийн агуулгад тавих шаардлагыг тодорхойлоход ач холбогдолтой. Аливаа хууль тогтоомжид дагалдах хуулийн хэлбэрээр “зарчмын шинжтэй өөрчлөлт” оруулахыг хязгаарлах саналыг мөн өгсөн болно.
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын төлөвлөлт, дэс дараалал			
2	7 дугаар зүйл	Тус зүйлд “Үндсэн чиглэлд тусгагдаагүй асуудлаар хууль тогтоомж батлан гаргах шаардлагатай бол Засгийн газар Үндсэн чиглэлд оруулах өөрчлөлтийг жил бүрийн эхний улиралд багтаан баталж, Улсын Их Хуралд танилцуулна” гэсэн заалт нэмэх.	Сүүлийн жилүүдэд яаралтай горимоор хууль батлах явдал нэмэгдэх болсон нь хууль тогтоомж боловсруулах ажлын төлөвлөлт хангалтгүй байгааг харуулж байна. Үүнийг хязгаарлахын тулд Үндсэн чиглэлд тусгагдаагүй асуудлаар хууль батлах хэрэгцээ гарсан тохиолдолд түүнд заавал өөрчлөлт оруулах шаардлага тогтоох нь зүйтэй. Ийнхүү хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын төлөвлөлтийг сайжруулснаар судалгаа шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлгийг зохих ёсоор хийх боломж бүрдэнэ.
3	11 дүгээр зүйл	“Үндсэн чиглэлд тусгагдсан хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын зардлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган санхүүжүүлнэ” гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	Тэрчлэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг ийнхүү жил бүр нарийвчлан төлөвлөснөөр уг ажлын зардлыг тухайн жилийн төсөвт тусган баталгаажуулах боломж бүрдэнэ. Учир нь төрийн байгууллагуудын төсөвт хуулийн төсөл боловсруулах ажлын зардал ихэвчлэн тусдаггүй нь тооцоо, судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг зохих ёсоор хийгдэхгүй байхад нөлөөлж байна. Хууль боловсруулах ажлын төлөвлөлтөд анхаарах бусад асуудлыг “Хууль тогтоомжийн төслийн ил тод байдал, олон нийтийн хэлэлцүүлгийн шаардлагын хэрэгжилт” ¹⁰ судалгааны тайлангаас дэлгэрүүлэн авч үзнэ үү.

¹⁰ “Хууль тогтоомжийн төслийн ил тод байдал, олон нийтийн хэлэлцүүлгийн шаардлагын хэрэгжилт” судалгааны тайлан, 29 дэх хуудас, <https://forum.mn/product/459176>

№	ХТТХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
4	8 дугаар зүйл	8.1 дэх заалтыг “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах дэс дараалал бүхий үе шатаар зохион байгуулна” гэж өөрчлөх.	Хууль санаачлагчид ХТТХ-ийн 8.1-д заасан дэс дарааллыг баримтлахгүй байна. Тодруулбал, хуулийн төслийг үзэл баримтлалаас түрүүлж боловсруулах, суурь судалгааг хуулийн төсөл боловсруулсны дараа эсхүл зэрэгцүүлж хийх явдал түгээмэл байна. Энэ нь Үзэл баримтлал нь суурь судалгаанд үндэслэсэн байх, хуулийн төсөл нь Үзэл баримтлалдаа нийцсэн байх зэрэг хууль тогтоомжийн төсөлд тавигдах үндсэн шаардлага зөрчигдөхөд хүргэж байна.
Хуулийн төслийн үзэл баримтлал			
5	14 дүгээр зүйл	14.4 дэх хэсгийг хасах.	Агуулгын хувьд үзэл баримтлалтай холбоогүй төдийгүй 26 дугаар зүйлтэй давхцаж байна.
6		14.6 дахь хэсэгт “Багц хуулийн үзэл баримтлалыг нэгтгэн боловсруулсан бол түүнд багтсан анхдагч хууль болон шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ шаардлага, хүлээж буй үр дүн, хамрах хүрээ, Үндсэн хууль бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгааг тусгах” гэсэн заалт нэмэх.	
7		14.7 дахь хэсэгт “яаралтай горимоор өргөн мэдүүлэх хуулийн төслийн үзэл баримтлалд тухайн хууль нь МУИХЧХДТХ-ийн 33 дугаар зүйлд заасан үндэслэл, шаардлагад нийцсэн эсэхийг тусгах.	Яаралтай горимоор өргөн мэдүүлэх хуулийн төслийн үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдалд ямар эрсдэл үүссэн, түүнийг урьдчилан тооцох боломжгүй байсан шалтгаан, хойшлуулшгүй арга хэмжээ авах шаардлага, тухайн эрсдэлийг арилгахад хэрхэн нөлөөлөх зэргийг тусгах нь зүйтэй.
8		Уг зүйлд багц хуулийн төсөлд багтсан анхдагч хуулийн төсөлд хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийж, 38 дугаар зүйлд заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлгийг дагнан хийх шаардлага нэмж тусгах.	Багц хуулийн хүрээнд анхдагч хууль батлах, эсхүл хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг шинэчлэх найруулах бол холбогдох суурь судалгаа хийж, хуулийн төслийг олон нийтээр тухайлан хэлэлцүүлэх нь зүйтэй.

№	ХТХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
9	25 дугаар зүйл	Уг зүйлд багц хуулийн төсөлд багтсан шинэчилсэн найруулгын төсөлд өмнө хэрэгжиж байгаа хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ хийх шаардлага нэмж тусгах.	
10	29 дүгээр зүйл	29.1.11-д байсан (хүчингүй болсон) “хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана” гэсэн заалтыг сэргээх.	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад “зорилго”, “зорилт” гэсэн заалт харилцан адилгүй байдлаар тусгагдсан байна. Гэхдээ “зорилт” нь агуулгын хувьд ихэвчлэн хуулийн зохицуулах харилцаатай давхардсан байдаг. Иймд 29.1.11 дэх заалтыг сэргээж, тус хуулиар хангахаар зорьж буй иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг зорилго болгон тусгах нь зүйтэй.
Хууль тогтоомжийг яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх			
11	МУИХЧХДТХ-ийн 33 дугаар зүйл	33.1 дэх хэсэгт заасан “үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан” гэснийг “Үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд үүссэн гэнэтийн эрсдэлийг бууруулах зорилгоор” гэж өөрчлөх.	Олон улсад хойшлуулшгүй нөхцөл байдлын улмаас хууль тогтоомжийг яаралтай горимоор хэлэлцэн батлах жишиг байдаг ч яаралтай горимоор хууль батлах үндэслэл, шаардлагыг нарийвчлан тодорхойлдог. Тухайлбал, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын удирдамжийн дагуу ¹¹ Европын улс орнуудад “цар тахал, байгалийн гамшиг, бусад хямрал”-ыг хойшлуулшгүй нөхцөл байдал гэж үзэн “түр зуурын” хууль зүйн арга хэмжээг яаралтай авч болохоор хуульчилсан байдаг. Тухайн нөхцөл байдал нь бодитой бөгөөд урьдчилан тооцох боломжгүй, гэнэт үүссэн болохыг нотлох шаардлага тогтоосон байдаг. Тэрчлэн яаралтай горимоор өргөн мэдүүлэгдсэн хуулийг парламент хүлээн авах, хэлэлцэх, хэрэгжилт үр дагаврыг үнэлэхтэй холбоотой тусгайлсан журам байдаг.

¹¹ ННФ, Бодлогын асуудал цуврал №48, “Хууль тогтоомжийг олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр хэлэлцэн батлах зохицуулалт, анхаарах асуудал”, <https://forum.mn/product/434676>

№	ХТХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
12	МУИХЧХДТХ-ийн 34 дүгээр зүйл	34.1-д заасан “энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан” гэснийг хасах.	Дээр дурдсанчлан яаралтай горимоор хууль өргөн мэдүүлэх хангалттай үндэслэл байгаа эсэхийг УИХ-ын Тамгын газар магадлан хууль зүйн дүгнэлтдээ тусгадаг байх. Үүний тулд МУИХЧХДТХ-ийн 34.1-дэх хэсэг буюу УИХ-ын Тамгын газраас хийх хууль зүйн дүгнэлтэд хамаарахгүй хууль тогтоомжийн жагсаалтаас яаралтай горимоор өргөн мэдүүлэгдсэн хууль тогтоомжийг хасах нь зүйтэй.
13		Уг зүйлд Улсын Их Хурал яаралтай хэлэлцэн баталсан хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дагаврыг тогтоосон хугацаанд үнэлж, нийтэд мэдээлэх зохицуулалт тусгах.	
14	ХТХ-ийн 4 дүгээр бүлэг	Хуулийн 4 дүгээр бүлэгт “Яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд тавих нэмэлт шаардлага” гэсэн тусгай зүйл нэмж, дараах зохицуулалт тусгах: - Үндэсний эдийн засгийн байдлыг алдагдуулах эрсдэл үүссэн эсхүл үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон, - Тухайн нөхцөл байдал нь урьдчилан тооцох боломжгүй бөгөөд хойшлуулшгүй арга хэмжээ авах бодит шаардлага үүссэн, түүнийг нотолсон байх, - Хуулийн зорилго, үйлчлэх хүрээ нь зөвхөн тухайн нөхцөл байдлаас үүссэн эрсдэл, үр дагаврыг арилгахад чиглэсэн байх.	

№	ХТХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
	ХТХ-ийн 4 дүгээр бүлэг	- Цаашид байнга үйлчлэх зохицуулалт агуулаагүй байх, - Хуулийн төсөлд хэрэгжих хугацааг тодорхой заах буюу тухайн нөхцөл байдал, түүний үр дагавар арилсан тохиолдолд дуусгавар болох.	
Дагалдах хууль			
15		29.3-т заасан “шаардлагатай тохиолдол” гэдгийг тодорхойлох шалгуур бий болгох: - Тухайн батлагдах хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай, - Нэр томьёо, зүйл, хэсэг, заалтын дугаарыг уялдуулах шаардлага үүссэн.	Дагалдах хуульд тавих шаардлага тодорхойгүйгээс тухайн хуулийг хэрэгжүүлэхтэй огт холбоогүй хууль батлах тохиолдол гарч байна. Тухайлбал, Монгол Улсын 2023 оны төсвийн хуулийг дагалдан батлагдсан Засгийн газар дахь хяналтын тухай хууль,¹² Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг дагалдан батлагдсан Газрын тухай, Кадастрын зураглал газрын кадастрын тухай, Зөвшөөрлийн тухай хуулиудын өөрчлөлт нь тухайн жилийн төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй хэрхэн холбогдох нь тодорхойгүй байв.¹³
16	29 дүгээр зүйл	Тус зүйлд “дагалдах хуулийн төсөлд зарчмын шинжтэй өөрчлөлт буюу дагалдах хуулийн өөрийнх нь үзэл баримтлал, зарчмыг алдагдуулах өөрчлөлт тусгахгүй” гэсэн заалт нэмэх.	Монгол Улсын 2023 оны төсвийн хуулийг дагалдуулан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулж, мэргэжлийн хяналтын чиг үүргийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэх, шинэ төрлийн хяналт буюу урьдчилан сэргийлэх хяналт бий болгосон зэрэг нь тухайн хуулийн үзэл баримтлалыг өөрчлөхүйц “зарчмын шинжтэй өөрчлөлт” байв.¹⁴ Мөн уг өөрчлөлтийг төсвийн тухай хуулийг дагалдуулан хийх шаардлагатай эсэх нь тодорхойгүй буюу төсвийн тухай хуулийн Үзэл баримтлал, танилцуулгад энэ талаар огт дурдаагүй байв.

¹² Нээлттэй нийгэм форум, Бодлогын асуудал цуврал №40 “Дагалдах хууль, түүнд тавигдах шаардлага: төсвийн тухай хуулийн дагалдах хуулиудад хийсэн дүн шинжилгээ”, 10 дахь хуудас, <https://forum.mn/product/352834>

¹³ Нээлттэй нийгэм форум, Бодлогын асуудал цуврал №38 “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хууль өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, өргөн барих зохицуулалтын шинжилгээ, 17 дугаар хуудас, <https://forum.mn/product/333892>

¹⁴ Нээлттэй нийгэм форум, Бодлогын асуудал цуврал №40 “Дагалдах хууль, түүнд тавигдах шаардлага: төсвийн тухай хуулийн дагалдах хуулиудад хийсэн дүн шинжилгээ”, 10-11 дахь хуудас, <https://forum.mn/product/352834>

№	ХТХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
Хуулийн төслийн танилцуулга			
17	33 дугаар зүйл	33.3 дахь хэсэгт багц хуулийн төслийн танилцуулгад тухайн багцад багтсан анхдагч хуулийн хэрэгцээ шаардлагыг тусгах тухай заалт нэмэх.	Багц хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгыг нэгтгэн боловсруулсан бол дэлгэрэнгүй танилцуулгад тухайн багц хуульд багтсан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг тухайлан дурдах нь зүйтэй.
18		33.4 дэх хэсэгт багц хуулийн төсөлд багтсан шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ шаардлагыг тусгах заалт нэмэх.	
Хуулийн төслийн бүрдүүлбэр, түүний ил тод байдал			
19	38 дугаар зүйл	38.2 дахь хэсгийг “Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд хууль тогтоомжийн төсөл болон энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан баримт бичгийг Нийтийн мэдээллийн ил тод байдлыг тухай хуульд заасан нээлттэй өгөгдлийн стандартыг хангасан хэлбэрээр байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заана.” гэж өөрчлөн найруулах.	Хуулийн төслийн бүрдүүлбэрийн ил тод байдал хангалтгүй байна. 2020-2024 онд боловсруулалтын шатанд олон нийтэд ил тод болгосон 164 хуулийн төслийн дөнгөж 59 нь суурь судалгааны тайлан, 113 нь үзэл баримтлал, 56 нь дагалдах хуулийн төсөл, 43 нь үр нөлөөний үнэлгээний тайлан, 40 хувь нь зардлын тооцоо, 53 нь товч танилцуулга, 48 нь дэлгэрэнгүй тайланг хамт нийтэлжээ. ¹⁵ Иймд ХТХ-ийн 40 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн бүрдүүлбэрийг бүхэлд нь ил тод болгох нь зүйтэй. Ялангуяа дагалдах хуулийн төсөл болон холбогдох байгууллагуудын хууль зүйн дүгнэлт, санал зөвлөмжийг нээлттэй болгох нь олон нийтийн хэлэлцүүлгийн үр нөлөөг нэмэгдүүлэхээс гадна судалгааны өндөр ач холбогдолтой.
20		38 дугаар зүйлд “энэ хуулийн 38.2-т заасан нэгдсэн системд хуулийн төслийг өргөн мэдүүлсэн, баталсан зэрэг явцын мэдээлэл болон УИХ-ын чуулганы хуралдааны тэмдэглэлийг байршуулна” гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	2020-2024 онд боловсруулагдсан 254 хуулийн төслийн 187 нь өргөн мэдүүлэгдэж, 92 нь эцэслэн батлагджээ. Гэсэн хэдий ч хуулийн төслийг өргөн мэдүүлээгүй шалтгаан эсхүл өргөн мэдүүлэгдсэн төслийг УИХ-аас буцаасан, хууль санаачлагч эргүүлэн татсан эсэх тухай мэдээллийг нийтлэхгүй байна. ¹⁶

¹⁵ “Хууль тогтоомжийн төслийн ил тод байдал, олон нийтийн хэлэлцүүлгийн шаардлагын хэрэгжилт” судалгааны тайлан, 31-35 дугаар хуудас, <https://forum.mn/product/459176>

¹⁶ “Хууль тогтоомжийн төслийн ил тод байдал, олон нийтийн хэлэлцүүлгийн шаардлагын хэрэгжилт” судалгааны тайлан, 29- 30 дугаар хуудас, <https://forum.mn/product/459176>

№	ХТХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
	38 дугаар зүйл		Иймд хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх шатны мэдээлэл, тэр дундаа хууль зүйн дүгнэлт, чуулганы хуралдааны тэмдэглэлийг нийтэд ил тод болгох нь зүйтэй.
21	40 дүгээр зүйл	40.1.6- д “энэ хуулийн 15.2-т заасан зөвлөмж” гэж нэмэх	
Олон нийтийн хэлэлцүүлэг			
22		12.2.11-д заасан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.8 дах заалтаас бусдыг хасах.	Судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх, ил тод нээлттэй байдал, бүх талын оролцоог хангах нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах үндсэн зарчим юм. Ийм ч учраас хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад нөхцөл байдлын шинжилгээ, эдийн засаг, байгаль орчин, нийгэм, хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийх, олон нийт, холбогдох талуудаар хэлэлцүүлэх шаардлагыг хуулиар тогтоосон. ХТХ-д заасан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийг батлахад тооцоо судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр батлах зохицуулалт үүнд нийцэхгүй юм.
23	12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг	12.2.21 дэх заалтыг хасах.	Төрийн захиргааны байгууллагын бүтэц, тогтолцоог өөрчлөх, ялангуяа агентлаг шинээр байгуулах, татан буулгах, харьяаллыг тогтоох асуудлыг тооцоо судалгаагүй хийснээс богино хугацаанд дахин дахин өөрчлөх, түүнээс үүдэн төсвийн зардал нэмэгдэх тохиолдол гарч байна. Тухайлбал, 2021 онд хүүхэд харах үйлчилгээний асуудлыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн боловч мөн ондоо багтаан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний эрхлэх асуудалд буцаан шилжүүлжээ. Эдгээр болон бусад жишээг https://forum.mn/product/352834?page=33 судалгааны тайлангийн 8 дахь нүүрээс үзнэ үү.

№	ХТТХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
24	38 дугаар зүйл	38.9-д “12.2.22” гэж заасныг хасах.	УИХ нь төлөөллийн байгууллага болохын хувьд үйл ажиллагааных нь журам, процессын өөрчлөлтийн асуудлаар олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд мэдээлэл авч, санал шүүмж өгч оролцох ёстой. Нөгөө талаар ил тод байдал нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим болно. ¹⁷ Иймд ХТТХ-ийн 38.9-д заасан олон нийтийн хэлэлцүүлэг шаардахгүй нөхцөлөөс Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль буюу 12.2.22-ыг хасах нь зүйтэй.
25		38.9-д “12.2.5, 12.2.11, 12.2.23” гэж заасныг хасах.	Эдгээр нь 38.4 дэх хэсэгт заасан худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл буюу заавал олон нийтээр хэлэлцүүлэх, гэхдээ бүр 60-аас доошгүй хоногийн хугацаанд хэлэлцүүлэх хуулиуд байна.
26	27 ² дугаар зүйл	27 ² дугаар зүйл буюу Нэг удаагийн үйлчлэл бүхий хуулийн төсөлд тавих нэмэлт шаардлага гэсэн зүйл нэмэх.	Хуулийн төслийн төрлөөс хамааран түүнд тавих шаардлагыг тодорхойлдог Гэтэл Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Татварын өршөөл үзүүлэх тухай хууль гэх мэт нэг удаагийн үйлчлэл бүхий хуулиуд нь ХТТХ-ийн 22 дугаар зүйлд заасан хуулийн төслийн төрлийн алинд ч хамаарахгүй байна. Үүнээс шалтгаалан судалгаа шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлэг хийгдэхгүй байна.

¹⁷ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг.

№	ХТТХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
27	38 дугаар зүйл	38 дугаар зүйлд “энэ хуулийн 8.1.1-д заасан эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх талуудтай тухайлсан хэлэлцүүлэг хийх, хэлэлцүүлгийн арга хэлбэр нь тэдний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн байна” гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	38 дугаар зүйлд заасан олон нийтийн хэлэлцүүлгийн журмыг аль болох нарийвчлан тодорхойлох. Ялангуяа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудыг зөв тодорхойлсон, хуулийн төслөө танилцуулж, саналаа бэлтгэх хугацаа олгосны үндсэн дээр, тэдэнд тохирсон арга хэлбэрээр хэлэлцүүлэг хийх гэх мэт процессыг хуульчилж өгөх шаардлагатай. Учир нь хуулийн төслийн хэлэлцүүлэгт тавих шаардлага хэт ерөнхий байгаагаас зохих ёсоор хийгдэхгүй, хууль санаачлагч эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудыг тодорхойлж, санал авах ажиллагааг тэр бүр хийхгүй байна. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд явагдсан газар, ашигт малтмал, байгаль орчны хуулийн төслийн хэлэлцүүлгүүдийг харахад уул уурхай бүхий орон нутгийн иргэдийн оролцоог огт хангаагүй. Орон нутагт хэлэлцүүлэг зохион байгуулсан боловч тэр нь ихэвчлэн аймгийн түвшинд төрийн албан хаагчдын дунд хийгдсэн байдаг. Тэрчлэн хуулийн төслөөр дагнасан хэлэлцүүлэг хийхийн оронд өөр бусад арга хэмжээтэй хавсаргаж хийдэг зэрэг нь хэлэлцүүлгийн ач холбогдлыг бууруулж байна.
28		38 дугаар зүйлд “тухайн хуулийн зохицуулах харилцаа болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудын онцлогоос хамааран хуулийн төсөлд санал авах хугацааг ялгамжтай тогтоож болно” гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	

№	ХТТХ-ийн холбогдох зүйл, заалт	Санал	Тайлбар, үндэслэл
Хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх			
29	41 дүгээр зүйл	41.3.1-ийг “Энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан шаардлагыг хангасан эсэх” гэж өөрчлөх.	Төрийн холбогдох байгууллагатай зөвшилцөх, санал авах гэх мэт бусад хуулиар тогтоосон шаардлага зөрчигдөх болсон. Жишээ нь, 2023 оны 11 сарын 23-ны өдөр батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийг батлахад Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхтэй зөвшилцөх зэрэг шүүхийн хууль тогтоомжийн шаардлага зөрчигдсөн.
30		41.3.3 дахь заалтыг “хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг зохих журмын дагуу хийсэн эсэх, хуулийн төслийг дээрх судалгаанд үндэслэн боловсруулсан эсэх” гэж өөрчлөн найруулах.	Эдгээр судалгааг хуулийн төсөл боловсруулахтай зэрэгцүүлж эсхүл нөхөж хийх, холбогдох аргачлалыг бүрэн баримтлахгүй буюу чанаргүй хийх явдал түгээмэл байна. Иймд УИХ-ын Тамгын газар эдгээр судалгаа агуулга, чанарт дүгнэлт өгдөг байх нь зүйтэй.
31		41 дүгээр зүйлд ил тод байдал, олон нийтийн оролцоог зохих ёсоор хангасан эсэхийг хянаж, хууль зүйн дүгнэлтэд тусгах зохицуулалт нэмэх.	Хуулийн төслийн хэлэлцүүлгийн чанар буюу ил тод байдал, хэлэлцүүлэг зохих ёсоор хийгдсэн эсэхэд хяналт тавьдаггүйгээс хуулийн төслийг бүрдүүлбэрийг бүрэн ил тод болгохгүй, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудад хуулийн төслийг танилцуулж, санал авах ажиллагаа хэрэгжихгүй байна.
32		41.5-д заасан хууль зүйн дүгнэлт гаргах хугацааг уртасгах.	Хууль зүйн дүгнэлтийн цар хүрээг дээр дурдсанчлан өргөжүүлж, дүгнэлт боловсруулах хугацааг уртасгах.

Хуулийн шүүмж боловсруулсан:
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер
Д.Эрдэнэчимэг



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар-14240
Монгол Улс
Утас: (976) 76113207
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn